

Шинэ судалгаа: Олборлох үйлдвэрлэл эрхлэгч компаниудын “Ашиг хүртэгч жинхэнэ эзэд”-ийн ил тод байдлыг хангах нь



Монгол Улсын эрдэс баялгийн салбарт дээрх эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор олборлох үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанаас “ашиг хүртэгч жинхэнэ эзэд”-ийн ил тод байдлыг хангах хүрээнд уг судалгааг хийжээ. Нээлттэй Нийгэм Форумын захиалгаар хийгдсэн энэхүү судалгаа нь 2016 онд шинэчлэн батлагдсан ОУИТБС-ын стандартын хэрэгжилтийг хангахад хувь нэмэр оруулах, олборлох үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанаас ашиг хүртэгч жинхэнэ эздийн мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх арга замыг тодорхойлж, Зөвлөмж боловсруулах чиглэлээр хийгдсэн ажил ажээ. Уг бодлогын судалгаагаар Монгол Улсын эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн ашиг хүртэгч эздийг тодорхойлох, төрийн байгууллагаас мэдээлэл цуглуулах, шалган баталгаажуулах болон олон нийтэд ил тод болгох үйл явцын өнөөгийн нөхцөл байдалд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд үнэлэлт дүгнэлт өгчээ.

Дараах линкээр орж судалгаатай танилцана уу.

[Олборлох үйлдвэрлэл эрхлэгч компаниудын “Ашиг хүртэгч жинхэнэ эзэд”-ийн ил тод байдлыг хангах нь](#)